



ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 4/15

Баян-Өндөр сум

Албан тушаалын тодорхойлолт батлах  
тухай

Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9, 10.12 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 378 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1а/12 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын ахлах байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилтийг Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт дэвшүүлсэн төрийн бүтээмжийг сайжруулах зорилт, шинэтгэлийн үйл явцтай уялдуулан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны хяналтын улсын ахлах байцаагч Ч.Биндэръяа, Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчийн Б.Нарангоо нарт үүрэг болгосугай.

3. Албан тушаалын тодорхойлолтыг хүний нөөцийн системд бүртгэхийг бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Эрдэнэжаргалд даалгасугай.

ДАРГА  О.АРИУНГЭРЭЛТ



Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 04 сарын 19-ны өдрийн  
№9/15-р тушаалын 1 дүгээр хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан  
огноо:

Байгууллагын нэр:

Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх  
Боловсрол, шинжлэх ухааны газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Боловсрол, шинжлэх ухааны хяналтын  
улсын ахлах байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Орхон аймаг, Баян-өндөр сум,  
Уурхайчин баг, Захиргааны 4-р байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Боловсрол, шинжлэх ухааны салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг бодлого төлөвлөлт, хяналтын нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:			
1. Эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын холбогдох бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх. 2. Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, зөрчил дутагдлыг таслан зогсоох 3. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 4. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлэх, тайлагнах;	Бодлого, төлөвлөлтийг орон нутагт хэрэгжүүлсэн байна.	Г
	2. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг төлөвлөх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;	Хяналт шалгалтын үр дүн дээшилж, эрх зүйн орчин сайжирсан байна.	Г
	3. Салбарын хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсыг боловсронгуй болгоход санал өгөх, хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийг цахим системд бүртгэх, хэрэглэгчийн хяналтын хуудсыг сурталчлах;	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Г
	4. Салбарын хяналтын чиглэлээрх аж ахуй нэгж байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн хэрэглээ, үйлчилгээний соёл, мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, иргэд, бизнес эрхлэгчдийг мэдээлэл, зөвлөмжөөр хангах;	Аж ахуйн нэгж байгууллагын хуулийн сахин мөрдөлт сайжирсан байна.	Г
	5. Цаг үеийн шинжтэй болон онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах;	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г

2 дугаар зорилтын хүрээнд	1.Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх;	Хяналт шалгалт бүрэн гүйцэд хийгдсэн байна.	Г
	2.Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г
	3.Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г
	4.Улсын байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.	Г
	5.Шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргах;	Хууль, журмын дагуу шийдвэрлэгдсэн байна.	Г
	6.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх.	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулсан байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж холбогдох албан тушаалтантай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;	Ажлын зохион байгуулалт, төлөвлөлт, гүйцэтгэл хангагдсан байна	Г
	2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, шийдвэрлэх;	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Г
	3.Байгууллагын үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах;	Олон нийтэд сурталчилсан байна.	Г
	4.Холбогдох төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах;	Хамтын ажиллагаа өргөжсөн байна.	Г

	5.Иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангах, хяналт шалгалтын чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6.Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх;	Заавар, журам, стандартад нийцсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна.	Г
	2.Холбогдох асуудлаар ажлын хэсэг, комисс, тендерийн болон стандартчиллын техникийн хороо зэрэгт ажиллах;	Хариуцлагатай гүйцэтгэсэн байна.	Г
	3. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөх	Мөрдсөн байна.	Г
	4. Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсрол судлал /011101/</li> <li>- Багш, мэргэжлийн /0114/</li> </ul>	
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байх.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд 3-оос доошгүй жил, эсхүл мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- салбарын хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх;</li> <li>- цахим хяналтын систем дэх хяналт шалгалтын мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;</li> <li>- хяналтын объектуудад эрсдэлийн үнэлгээний дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;</li> <li>- хариуцсан хяналтын салбарт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;</li> <li>- хариуцсан хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт</li> </ul>

		<p>шалгалтын дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;</li> <li>- хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, шийдвэрийн төсөлд тусгах;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх;</li> <li>- бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачлагыг дэмждэг байх;</li> <li>- аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;</li> <li>- аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олонтой хүндэтгэлтэй харилцах, зохих мэдээлэл, зөвлөмж өгөх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах;</li> <li>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;</li> <li>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;</li> <li>- албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах, нууцыг хадгалах;</li> <li>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;</li> </ul>

#### IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Бодлого төлөвлөлт хяналтын нэгжлийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй.

Бусад харилцах субъект:

- Төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан
- Бусад салбарын хяналтын улсын байцаагчид
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

..... / Д.ЭРДЭНЭЖАРГАЛ /

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20 23 оны 04 сарын 12-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 2019.12.05

Дугаар: 378

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.04.12

Дугаар: 4/15

(тамга/тэмдэг)

ДАРГА ..... / О. АРИУНГЭРЭЛТ /

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

20 23 оны 04 сарын 12-ны өдөр

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын  
даргын 2023 оны 04 сарын 19-ны өдрийн  
№4/15-р тушаалын 2 дугаар хавсралт



## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Төрийн хяналт, шалгалтын тухай хууль

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан

ОГНОО:

Байгууллагын нэр:

Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх  
Боловсрол, шинжлэх ухааны газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Цөмийн болон цацрагийн хяналтын  
улсын байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Захиргааны 4-р байр, Уурхайчны  
гудамж, Уурхайчин баг, Баян-Өндөр  
сум, Орхон аймаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цөмийн болон цацрагийн хяналт шалгалтын бодлого, стратегийг боловсруулах, дүрэм, журам, заавар, стандарт боловсруулах, салбарын хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.



Албан тушаалын зорилт:

- 1.Салбарын хяналтын чиглэлээр хяналт шалгалтын бодлого, стратеги, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон дүрэм, журам боловсруулах, хэрэгжүүлэх;
- 2.Салбарын улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын биелэлтэд хяналт тавих;
- 3.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 4.Холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хуультогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрхзүйн актын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх  Цөмийн болон цацрагийн аюулгүй айдлыг хангахтай холбогдсон нийтлэгдүрэм, журам, заавар, стандартыг боловсруулах;	Хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.	Г
	2.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, цаашдын бодлого, стратегийн талаарх санал, дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;	Үр нөлөө бүхий хяналт шалгалт хийх эрх зүйн орчин бүрдсэн байна.	Г
	3.Цөмийн болон цацрагийн болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, ослын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг мэргэжлийн холбогдох байгууллагатай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	4.Цаг үеийн шинжтэй онцгой нөхцөл байдалд зохих журмын дагуу ажиллах.	Зохиххуультог тоомжийнхүрээндхэрэгжүүлсэнбайна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Салбарын улсын ахлах байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын баримт бичиг үйлдэх;	Хяналт шалгалт бүрэн гүйцэт хийгдсэн байна.	Г,Х,Ш
	2.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийг батлах;	Хяналт шалгалт бүрэн гүйцэт хийгдсэн байна.	Г,Х,Ш
	3.Салбарын хяналтын чиглэлээр хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, хяналт шалгалтын мэдээллийг	Холбогдох хууль тогтоомжийн	Г,Х

цахим системд бүртгэх;	хүрээнд хэрэгжүүлсэн байна.	
4.Тусгай зөвшөөрлийн баримт бичигт цацрагийн аюулгүйн үнэлгээ хийх, иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.	Т,Г
5.Улсынбайцаагчийнүйлажиллагааболонх яналтшалгалттайхолбогдуулангаргасанго мдол, хүсэлтийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх;	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.	Т, Г, Ш
6.Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтлөх, цацрагтай ажиллагчийн мэргэжлийн шарлагын тунд хяналт тавих, шарлагын тунгийн мэдээллийн сан бүрдүүлэх;	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.	Г, Х
7.Цацраг идэвхт хаягдлыг устгах, булшлах ажилд хяналт тавьж ажиллах;	Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдсэн байна.	Г, Х, Ш
8.Цөмийн материал, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэл хөтлөх мэдээллийн сан бүрдүүлэх;	Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдсэн байна.	Г
9.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих хууль, журмын дагуу хэрэгжүүлэх;	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, журмын дагуу явуулсан байна.	Г, Х, Ш
10.Улсын ахлах байцаагчийн бусад нийтлэг чиг үүрэг болон хууль тогтоомж, хэм хэмжээний актад заасан өдөр тутмын бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;	Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдсэн байна.	Г
11.Хүрээлэн байгаа орчны болон ахуйн хэрэглээний бараа, материал, хүнсний бүтээгдэхүүн, ундны ус, барилгын материалын цацрагийн түвшний хяналт шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг тогтоох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх, чанарын баталгаажилтыг хангах арга хэмжээ авах.	Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдсэн байна.	Т, Г, Х, Ш

3 дугаар зорилтын хүрээнд	1.Жил, сар, улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах;	Заавар, журам, стандартад нийцсэн байна.	Г
	2.Нэгжийн үйл ажиллагааны болон хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлэх мэдээ, тайлан бэлтгэх, сурталчлах;	Олон нийтэд мэдээлсэн байна.	Т, Г
	3.Цөмийн энергийн тухай хуулийн 18.8 дахь заалтын дагуу холбогдох саналыг боловсруулах;	Стандартын шаардлага хангасан байна.	Г
	4.Албан тушаалын чиг үүрэгт хамаарах албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг судалж, барагдуулах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	5.Иргэн, хуулийн этгээдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага, зөвлөмж, мэдээллээр хангах, хяналт шалгалтын чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, семинар зохион байгуулах;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	6.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлэх, эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах.	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна.	Г
	2.Яамны удирдлага, бусад нэгжийн чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г
	3.Холбогдох асуудлаар ажлын хэсэг, комисс, тендерийн болон стандартчиллын техникийн хороо зэрэгт ажиллах;	Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.	Г
	4.Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөх;	Мөрдсөн байна.	Г

	5.Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;	Ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлсэн байна.	Г
	6.Хамт олны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;	Идэвхтэй оролцсон байна.	Г
	7.Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг маягтын дагуу мэдээлэх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв, хугацаанд нь гаргасан байна.	Г
	8.Хууль, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Зохих хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн байна.	Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>-геофизик /053207/;</li> <li>-программ хангамж /061302/;</li> <li>-физик /053301/;</li> <li>-цөмийн физик /053305/;</li> <li>-хими /053101/;</li> <li>-химийн боловсруулалтын технологи /071103/;</li> <li>-цөмийн инженерчлэл /071312/;</li> <li>-цөмийн технологи /071313/;</li> <li>-электроникийн инженерчлэл /071401/;</li> <li>-эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалтын инженер /078810/.</li> </ul>		
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- салбарын хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх;</li> <li>- цахим хяналтын систем дахь хяналт шалгалтын мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах;</li> <li>- хяналтын объектуудад эрсдэлийн үнэлгээний дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах;</li> <li>- хариуцсан хяналтын сал барт эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;</li> <li>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;</li> <li>- хариуцсан хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын дүнд шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах</li> <li>- бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>		

	<p>Асуудал шийдвэрлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; салбарын хяналтын чиглэлээр тулгамдаж буй асуудлыг судлах, дээд шатны удирдлагад танилцуулах;</li> <li>- тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах;</li> <li>- хяналт шалгалтыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, шийдвэрийн төсөлд тусгах;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>
	<p>Багаар ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх;</li> <li>- бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх;</li> <li>- аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;</li> <li>- аливаа сергөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад.</li> </ul>
	<p>Бусад</p>	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах;</li> <li>- албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх;</li> <li>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;</li> <li>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;</li> <li>- албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах, нууцыг хадгалах;</li> <li>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх.</li> </ul>

**IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

- Байхгүй

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага;
- Төрийн бус байгууллага;
- Олон улсын байгууллага;
- Иргэн, хуулийн этгээд.

**V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолт  
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,  
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын  
шийдвэр:

Албан тушаал:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

..... *Д.Эрдэнэжаргал* /Д.ЭРДЭНЭЖАРГАЛ/

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр,  
өөрийн нэр)

2023 оны 04 сарын 12-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 2019.12.05

Дугаар: 378

**VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:**

Байгууллагын нэр:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023.04.12

Дугаар: 4/15

(тамга/тэмдэг)

ДАРГА ..... /О.АРИУНГЭРЭЛТ/

(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2023 оны 04 дугаар сарын 12-ны өдөр